

“ХААН СОЁМБО АУДИТ” - ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тариалан сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2026/201/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Хөвсгөл аймаг
2025 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Х.Энхтуяа
Утас: 89182456 Цахим хаяг: enkhtuyakh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас: 95648028, 98828028
Цахим хаяг: zaya96884510@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/206
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ТАРИАЛАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.НЯМДАВАА ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тариалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тариалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвөөс санхүүжих дүнг 109,267.0 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар цалин олголттой холбоотой 2,983.4 мянган төгрөгийн, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 5,800.0 мянган төгрөгийн зөрчил илэрч холбогдох шийдвэрийг гаргасан болно.

Бусад асуудлын хэсэг

Тариалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт, 21 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 94.4 хувьтай тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	596,369,083.67	321,794,537.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	342,511,617.60	65,840,254.60
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	342,511,617.60	65,840,254.60
3121	Төгрөг	342,511,617.60	65,840,254.60
31211	Төрийн сангийн харилцах	342,511,617.60	65,840,254.60
33	АВЛАГА	6,002,342.60	7,685,304.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,429,342.60	6,164,104.00
3351	Байгууллагаас авах авлага	1,573,000.00	1,521,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	247,855,123.47	248,268,979.23
351	Түүхий эд материал	1,482,900.00	822,500.00
35130	Эм боох материал	1,482,900.00	822,500.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	30,624,600.00	21,471,911.00
354	Хангамжийн материал	215,747,623.47	225,974,568.23
35410	Бичиг хэргийн материал	930,351.00	1,493,351.00
35420	Аж ахуйн материал	53,128,381.60	70,320,031.60
35430	Сэлбэг хэрэгсэл	4,021,300.00	805,000.00
35450	Барилга засварын материал	7,535,800.00	3,190,200.00
35460	Хүнсний материал	41,946,060.00	35,596,873.50
35470	Бусад хангамжийн материал	108,185,730.87	114,569,112.13
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,567,808,878.97	2,385,952,313.32
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,567,808,878.97	2,385,952,313.32
392	Биет хөрөнгө	2,454,695,886.99	2,275,878,313.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,595,958,771.44	2,595,958,771.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-770,333,144.48	-856,187,970.28
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	702,723,714.08	779,031,119.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-250,822,168.94	-410,521,689.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	201,638,095.12	218,973,086.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	-106,487,914.38	-132,080,640.44
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,965,171.26	17,965,171.26
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,853,848.01	-12,166,544.97
39217	Ном	74,907,010.90	74,907,010.90
393	Биет бус хөрөнгө	113,112,991.98	110,074,000.00
39301	Програм хангамж	15,248,645.00	15,248,645.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-12,209,653.02	-15,248,645.00
39303	Бусад биет бус хөрөнгө	110,074,000.00	110,074,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,164,177,962.64	2,707,746,851.15
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	106,254,935.00	50,196,240.62
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	106,254,935.00	50,196,240.62
413	Өглөг	106,254,935.00	50,196,240.62
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	59,700.00
4136	Бусад өглөг	106,254,935.00	50,136,540.62

41361	Байгууллагад төлөх өглөг	<u>106,254,935.00</u>	<u>49,936,540.62</u>
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	<u>0.00</u>	<u>200,000.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>3,057,923,027.64</u>	<u>2,657,550,610.53</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	<u>3,057,923,027.64</u>	<u>2,657,550,610.53</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	<u>1,200,377,201.03</u>	<u>1,200,377,201.03</u>
51101	Өмч: - төрийн	<u>1,200,377,201.03</u>	<u>1,200,377,201.03</u>
512	Хуримтлагдсан үр дүн	<u>-344,289.12</u>	<u>-400,716,706.23</u>
51210	Өмнөх үеийн үр дүн	<u>-344,289.12</u>	<u>-344,289.12</u>
51220	Тайлант үеийн үр дүн	<u>0</u>	<u>-400,372,417.11</u>
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	<u>1,857,890,115.73</u>	<u>1,857,890,115.73</u>
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>3,164,177,962.64</u>	<u>2,707,746,851.15</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	<u>4,592,609,400.30</u>	<u>5,240,374,677.26</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>217,292,100.30</u>	<u>40,519,677.26</u>
1200	Нийтлэг татварын бус орлого	<u>217,292,100.30</u>	<u>40,519,677.26</u>
120017	Төсөвт байгууллагын өөрийн орлого	26,447,200.00	11,133,600.00
13	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,447,200.00	11,133,600.00
1310	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	0.00
131001	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-үндсэн хөрөнгө	4,200,000.00	24,566,396.00
1311	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-бараа материал	186,644,900.00	4,819,681.26
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>4,375,317,300.00</u>	<u>5,199,855,000.00</u>
	Улсын төвлөрсөн төсвөөс	<u>3,943,848,500.00</u>	<u>4,682,563,300.00</u>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,943,848,500.00	4,682,563,300.00
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	<u>431,468,800.00</u>	<u>517,291,900.00</u>
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөв/	431,468,800.00	517,291,900.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>4,460,116,247.36</u>	<u>5,640,747,094.37</u>
	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>4,460,116,247.36</u>	<u>5,640,747,094.37</u>
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>4,298,378,647.36</u>	<u>5,340,958,847.42</u>
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	<u>2,965,593,216.85</u>	<u>3,751,384,841.60</u>

210101	Цалин	1,888,648,375.68	2,129,697,970.60
210102	Нэмэгдэл цалин	901,167,734.17	1,357,483,603.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	98,267,200.00
210104	Урамшуулал	175,777,107.00	165,936,068.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	366,668,982.27	470,060,300.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	248,650,774.27	318,972,800.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	29,804,452.00	37,747,300.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	14,902,376.00	18,923,200.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	14,902,376.00	18,923,200.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	58,409,004.00	75,493,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	422,396,475.00	465,367,430.55
210304	Гэрэл цахилгааны зардал	16,606,072.49	31,999,886.55
2104	Түлш, халаалтын зардал	398,590,402.51	421,367,544.00
210401	Цэвэр, бохир усны зардал	7,200,000.00	12,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,082,402.00	47,192,300.00
210401	Бичиг хэргийн материал	3,016,928.00	15,289,500.00
210402	Тээвэр, шатахууны зардал	10,986,950.00	13,123,950.00
210403	Шуудан холбоо, интернетийн төлбөр	622,424.00	1,573,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	17,456,100.00	17,205,850.00
2105	Нормативт зардал	168,786,091.65	236,542,708.00
210501	Эм	2,510,100.00	3,660,400.00
210502	Хоол	166,275,991.65	232,882,308.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,284,944.50	15,000,000.00
210604	Урсгал засвар	7,284,944.50	15,000,000.00
2107	Томилолт, зочины зардал	1,312,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1,312,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,794,270.00	38,180,005.62

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	11,133,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,411,200.00	0.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	14,383,070.00	27,046,405.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	318,460,265.09	308,072,461.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,093,989.23	32,573,500.00
210902	Хичээл, сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	21,297,180.00	0.00
210902	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	222,069,095.86	275,498,961.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	161,737,600.00	299,788,246.95
213	Бусад урсгал шилжүүлэг	161,737,600.00	262,863,977.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	144,745,800.00	235,707,934.50
213204	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	16,991,800.00	27,156,043.00
213209	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	36,924,269.45
2133	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	132,493,152.94	(400,372,417.11)
213303	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)		0.00
3	Үнэ төлбөргүй гарсан зардал		0.00
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)		0.00
	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	<u>132,493,152.94</u>	<u>(400,372,417.11)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Хүснэгт 3. Өмч өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,200,377,201.03	1,857,890,115.73	(344,289.12)	3,057,923,027.64
2	Тайлант үеийн үр дүн			(400,372,417.11)	(400,372,417.11)
3	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,200,377,201.03	1,857,890,115.73	(400,716,706.23)	2.657.550.610.53

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Хүснэгт 4. Мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,401,764,500.00	5,210,988,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,447,200.00	11,133,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	26,447,200.00	11,133,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	26,447,200.00	11,133,600.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,447,200.00	11,133,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,375,317,300.00	5,199,855,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,943,848,500.00	4,682,563,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,943,848,500.00	4,682,563,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	431,468,800.00	517,291,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	431,468,800.00	517,291,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,310,451,138.48	5,418,583,963.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,310,451,138.48	5,418,583,963.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,127,445,338.48	5,128,008,105.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,970,123,828.00	3,752,919,603.00
210101	Үндсэн цалин	1,888,121,616.68	2,131,358,378.00
210102	Нэмэгдэл	906,225,104.32	1,357,357,957.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		98,267,200.00
210104	Урамшуулал	175,777,107.00	165,936,068.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	366,156,798.00	470,060,300.00
210201	Тэтгэврийн даатгал	248,138,590.00	318,972,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	29,804,452.00	37,747,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,902,376.00	18,923,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	14,902,376.00	18,923,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	58,409,004.00	75,493,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	421,468,800.00	465,367,430.55
210301	Гэрэл, цахилгаан	16,480,267.93	31,999,886.55
210302	Түлш, халаалт	397,788,532.07	421,367,544.00
210303	Цэвэр, бохир ус	7,200,000.00	12,000,000.00
2105	Нормативт зардал	174,667,045.25	226,179,171.50
210502	Хоол, хүнс	174,667,045.25	226,179,171.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	15,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	15,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,378,864.23	74,995,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,947,600.00	11,133,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	32,431,264.23	63,861,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,650,003.00	123,486,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	120,032,896.00	108,522,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,617,107.00	14,964,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	183,005,800.00	290,575,857.95
2132	Бусад урсгал шилжүүлэг	183,005,800.00	253,651,588.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	166,014,000.00	226,495,545.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,991,800.00	27,156,043.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	36,924,269.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		36,924,269.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	91,313,361.52	-207,595,363.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	116,474,845.00	69,076,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	116,474,845.00	69,076,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	116,474,845.00	69,076,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	116,474,845.00	69,076,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-116,474,845.00	-69,076,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-25,161,483.48	-276,671,363.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	367,673,101.08	342,511,617.60
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	342,511,617.60	65,840,254.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгт 5. төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<u>Татаас, санхүүжилтийн орлого</u>	5,668,365,800.00	5,210,988,600.00	457,377,200.00	92%
Улсын төсвөөс	4,791,830,300.00	4,682,563,300.00	109,267,000.00	98%
Орон нутгийн төсвөөс	517,291,700.00	517,291,700.00	0.00	100%
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	16,881,200.00	11,133,600.00	5,747,600.00	66%
Туслах үйл ажиллагааны орлого	0	0	0.00	

Урд оны үлдэгдлээс санхүүжүүлэх	342,362,600.00	0	342,362,600.00	0%
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,668,365,800.00	5,210,988,600.00	457,377,200.00	92%
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	5,668,365,800.00	5,487,659,963.00	180,705,837.00	97%
<u>Ажиллагчидтай холбогдсон Зардал</u>	4,365,843,700.00	4,222,979,903.00	142,863,797.00	97%
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,879,956,200.00	3,752,919,603.00	127,036,597.00	97%
Цалин	2,398,911,900.00	2,131,358,378.00	267,553,522.00	89%
Цалингийн тусгай нэмэгдлүүд	1,481,044,300.00	1,621,561,225.00	140,516,925.00	109%
<u>Нийгмийн хамгааллын шимтгэл</u>	485,887,500.00	470,060,300.00	15,827,200.00	97%
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	408,145,500.00	394,566,500.00	13,579,000.00	97%
Эрүүл мэндийн даатгалын хураамж	77,742,000.00	75,493,800.00	2,248,200.00	97%
<u>Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал</u>	502,291,700.00	465,367,430.55	36,924,269.45	93%
Гэрэл цахилгааны зардал	32,000,000.00	31,999,886.55	113.45	100%
Түлш, халаалтын зардал	458,291,700.00	421,367,544.00	36,924,156.00	92%
Цэвэр, бохир усны зардал	12,000,000.00	12,000,000.00	0.00	100%
<u>Үйл ажиллагаатай шууд холбоотой зардал</u>	520,809,800.00	508,736,771.50	12,073,028.50	98%
Хоол	226,701,000.00	226,179,171.50	521,828.50	100%
Бусад бараа үйлчилгээний зардал	177,957,100.00	173,938,400.00	4,018,700.00	98%
Мэдээллийн технологийн зардал	65,298,300.00	63,861,400.00	1,436,900.00	98%
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	18,972,200.00	18,624,200.00	348,000.00	98%
Урсгал засварын зардал	15,000,000.00	15,000,000.00	0.00	100%

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,881,200.00	11,133,600.00	5,747,600.00	66%
<u>Урсгал шилжүүлэг</u>	279,420,600.00	290,575,857.95	-11,155,257.95	104%
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	249,215,200.00	226,495,545.50	22,719,654.50	91%
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	30,205,400.00	27,156,043.00	3,049,357.00	90%
Төвлөрүүлэх шилжүүлэг		36,924,269.45	-36,924,269.45	
<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</u>		342,511,617.60	342,511,617.60	-
<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u>		65,840,254.60	-65,840,254.60	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 942,844.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2,444.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд ирүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага, Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 5,800.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 934,600.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

- Нэр бүхий 4 ажилтанд олгосон 1,800.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг буцаан суутгаагүй, 1 ажилтанд 644.5 мянган төгрөгийн цалинг ээлжийн амралтын олговортой давхардуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д ерөнхий нягтлан бодогч дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

3.2 Хариуцлага тооцох албан шаардлага

- Төсвийн шууд захирагч нь 2025 оны Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан хугацаанд бэлтгэж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй.

3.3 Албан шаардлага

- Багш ажилтнуудыг Улаанбаатар хотын сургуулийн үйл ажиллагаатай танилцуулах, туршлага судлуулахад төсвөөс 5,800.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн

тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 15 дугаар зүйлийн 2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасныг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй .

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Нэр бүхий 3 ажилтанд 538.9 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэрийн дагуу олгоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д ерөнхий нягтлан бодогч дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна. гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

1. Нэр бүхий 3 ажилтанд 538.9 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг нөхөн олгох;

Нийцлийн аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

2. Шилэн дансны цахим системд батлагдсан төсвийг 819,677.2 мянган төгрөгөөр, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 114,384.2 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1,1,6.1.6, 6.4.5.-д заасан мэдээллийг энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй

Өгсөн зөвлөмж:

2. Шилэн дансны цахим системд батлагдсан төсөв, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг үнэн зөв, бүрэн мэдээлэх;

Илрүүлэлт:

3. Байгууллагад 2025 оны 7 дугаар сард гарсан сул орон тооны мэдээллийг нийтэд зарлаагүй, ажлаас чөлөөлсөн ажилтныг буцаан томилохдоо хугацаатай гэрээг байгуулаагүй байна. Энэ нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1-д "Мэдээлэл хариуцагч ажлын байрны сул орон тооны талаарх Мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана." гэж заасныг зөрчсөн, "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй

Өгсөн зөвлөмж:

3. Байгууллагад гарсан ажлын байрны сул орон тооны мэдээллийг хуулийн хугацаанд нийтэд зарлах, ажлаас чөлөөгдсөн ажилтныг буцаан томилохдоо хугацаатай гэрээ байгуулан, цалин хөлсийг олгох;

Эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2026 оны 08 дугаар сарын 25 -ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд тус тус мэдээлж,

баталгаажуулна уу. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Хүснэгт 6. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэр бүхий 4 ажилтанд олгосон цалингийн урьдчилгааг суутгаагүй, 1 ажилтны цалин, ээлжийн амралтын олговор давхардсан	1	2,444.5	1	2,444.5				
Нэр бүхий 3 ажилтанд 0,5 сая төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тушаал шийдвэрийн дагуу олгоогүй	1	538.9					1	538.9
Дүн	3	2,983.4	1	2,444.5			2	538.9

Хүснэгт 7. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим системд мэдээлэл дутуу оруулсан	1	934,061.4					1	934,061.4
2025 оны 7 дугаар сард гарсан сул орон тооны мэдээллийг нийтэд зарлаагүй	1	0.0					1	0.0
Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан хугацаанд бэлтгэж ирүүлээгүй	1	0.0			1	0.0		

Төсвийн хөрөнгөөр багш ажилтнуудыг Улаанбаатар хотын сургуулийн үйл ажиллагаатай танилцуулах, туршлага судлуулсан.	1	5,800.0			1	5,800.0		
Дүн	4	939,861.4			2	5,800.0	2	934,061.4